



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 44

Есөнбулаг сум

“Архигүй–Алтайчууд” хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “ж”, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Архигүй-Алтайчууд хөтөлбөрийг 1 дүгээр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгаж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, дүнг жилийн бүрийн эцэст ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ



“АРХИГҮЙ-АЛТАЙЧУУД” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Сүүлийн жилүүдэд ажилгүйдэл, ядуурал, байгалийн гамшиг, гэнэтийн осол, гэр бүл, байгууллага, хамт олон, хүмүүсийн хоорондын зүй бус харилцаа, хүчирхийлэл бүхий таагүй орчин зэргээс шалтгаалан иргэдийн сэтгэцийн эрүүл мэнд илүүтэй хямарч, архидан согтуурах явдал улам бүр газар авч, архины хэрэглээ ба түүнээс үүдэн гарах сөрөг үр дагавар жил ирэх тутам нэмэгдэх хандлагатай байна.

Манай аймагт гэмт хэргийн сүүлийн 3 жилийн судалгаагаар 2015 онд 210 гэмт хэрэг үйлдэгсэний 68 гэмт хэргийг согтуугаар, 2016 онд 183 гэмт хэрэг үйлдэгсэний 72 гэмт хэргийг согтуугаар, 2017 онд 200 гэмт хэрэг үйлдэгсэний 58 гэмт хэргийг согтуугаар үйлдсэн байна.

Мөн согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, бусдын амгалан тайван аж төрөх амьдрах нөхцөлийг алдагдуулснаас 2014 онд 879 хүн, 2015 онд 751 хүн, 2016 онд 657 хүн, 2017 онд 476 хүн эрүүлжүүлэгдсэн дүнтэй байна.

Архидан согтуурсны улмаас эрүүл мэндээрээ хохирсон иргэдийн тоо жилээс жилд нэмэгдэж, халдварт бус өвчин, осол гэмтэл, хүн амын өвчлөл, нас баралтын зонхилох шалтгаан болж байна. Тухайлбал, сүүлийн 10 жилд зүрх судасны эмгэгээр нас барах явдал 4-5 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаанаас үзэхэд зүрх судасны эмгэгийн нас баралт 40 хувь, хавдрын өвчнөөр нас баралт 20 хувь, элэгний хавдрын нас баралт 42.3 хувь, ходоодны хавдрын нас баралт 15.6 хувь нь архинаас үүдэлтэй өвчин эзэлж байна.

Аймагт сүүлийн жилүүдийн байдлаар зүрх судасны өвчлөл улсын дунджийн хэмжээнд байгаа бөгөөд бусад аймгуудтай харьцуулахад өвчлөл өндөр байна. Наркологийн кабинетын хяналтад 2012 онд архины хамааралтай 72 хүн байсан бол 2016 онд 92 хүн буюу 21.7 хувиар өссөн төдийгүй сайн дурын эмчилгээнд 27 хүн хамрагдаж байгаа нь хангалттай тоо биш юм.

Архины хор хөнөөл, архидан согтуурахаас сэргийлэх талаар олон нийт, ялангуяа хүүхэд өсвөр үеийнхний мэдлэг муу, архинд донтох өвчнийг эрт илрүүлэх, хяналт тавих нийгэм, хамт олонд тулгуурласан тусламж үйлчилгээ байхгүй, архины хэрэглээнээс үүдэн гарах хүн амын өвчлөл, нас баралт, хүчирхийлэл, осол гэмтэл ихээр гарч, архидан согтуурахаас сэргийлэх, тэмцэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийт, гэр бүлийн оролцоо хангалтгүй, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах төсөв, хөрөнгө дутагдалтай байна.

Ийнхүү согтууруулах ундааны хэрэглээ нэмэгдэж, хэрэглэгчид нь улам бүр залуужиж, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг, түүнийг үйлдсэн хүний тоо төдийлөн буурахгүй, архинаас үүдэлтэй хүн амын өвчлөл, осол гэмтэл, нас баралт нэмэгдсээр

байгаа нь хүний тогтвортой хөгжилд саад болж буй гол хүчин зүйлийн нэг болж, иргэд, айл өрхийн амьдрал, улмаар аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хохирол учруулж байгаа нь шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Цаашид согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээ, хэрэглээнд тавих хууль, хяналтын механизмыг оновчтой, үр өгөөжтэй болгох, насанд хүрэгчдэд зохистой хэрэглээ төлөвшүүлэх, архидан согтуурснаас хүний эрүүл мэнд, гэр бүл, хамт олон, нийгмийн амьдралд учрах хор уршгийн талаар хүн амын мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, хүүхэд, өсвөр үеийнхнийг тохиолдлоор сонирхон согтууруулах ундаа хэрэглэхээс сэргийлэх, архи хэтрүүлэн хэрэглэгч, архинд донтох өвчтэй хүнийг эрт илрүүлж урьдчилан сэргийлэх, эмчлэх, хяналт тавих эрүүл мэнд, нийгмийн тусламж, үйлчилгээг боловсронгуй болгох, энэ ажилд оролцох төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, гэр бүл, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх зэргээр архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх өнөөгийн арга барилыг өөрчлөн шинэ арга, хандлагаар ажиллах шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилтууд

2.1. Хөтөлбөрийн зорилго

Согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээнд тавих хяналтыг сайжруулах замаар хүн амын согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, архидан согтуурснаас хүн амын эрүүл мэнд, нийгэмд учирах сөрөг үр дагаврыг бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт

2.2.1. “Архигүй-Алтайчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч, архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх.

2.2.2. Архидан согтуурснаас эрүүл мэнд, гэр бүл, хамт олон нийгмийн амьдралд учрах хор уршгийн талаарх хүн амын мэдлэг, хандлагыг дээшлүүлэн эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх.

2.2.3. Архинд донтох өвчин эмгэгийг эрт илрүүлэх, эмчлэн эдгэрүүлэх үйлчилгээг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотой зохион байгуулж үр дүнг тооцох.

2.2.4. Архинаас татгалзсан, эмчлэгдэж эрүүлжсэн хүнийг нийгэмшүүлэх, дэмжих үйлчилгээг хөгжүүлэх.

2.2.5. Архидан согтуурснаас нийгэмд учрах гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах, архи согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид тавих хяналт, нийгмийн хариуцлагыг сайжруулах.

2.3. Хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.3.1. Нэгдүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

2.3.1.1. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага иргэд, гэр бүл, хамт олны архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг хариуцлагыг тодорхой болгон хамтын ажиллагааг сайжруулах.

2.3.1.2. Архины асуудалтай иргэд, архи хэтрүүлэн хэрэглэгчид, архины хамааралт донтох эмгэгтэй иргэдийн дэлгэрэнгүй судалгааг гаргах.

2.3.1.3. Судалгааны үндсэн дээр архины асуудлаа шийдвэрлэх хүсэлтэй архи хэтрүүлэн хэрэглэгч, архины хамааралт донтох эмгэгтэй иргэдийг эдгэрүүлэх ажлыг зохион байгуулж, зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

2.3.1.4. Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг үр дүнтэйгээр төлөвлөн зохион байгуулах.

2.3.1.5. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журмыг шинэчилж мөрдүүлэх;

2.3.1.6. Согтууруулах ундаа худалддаггүй, хэрэглэдэггүй сар, өдөртэй болох талаар шийдвэр гаргаж хэрэгжүүлэх,

2.3.1.7. Архидан согтуурахтай тэмцэх сантай болох.

2.3.2. Хоёрдугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

2.3.2.1. Иргэд олон нийтэд хандсан нөлөөлөл, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

2.3.2.2. Хүн амын дундах архи тамхи болон бусад хорт зуршлын хэрэгцээг бууруулах, хорт зуршил хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг сургууль, гэр бүл, байгууллага хамт олны хүрээнд зохион байгуулах.

2.3.2.3. Архигүй орчин бүрдүүлсэн байгууллага хамт олон, өрх гэр бүл, иргэдийн тухай болон архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр зохион байгуулсан аливаа үйл ажиллагааг бүх нийтэд сурталчлан мэдээлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагууд санаачилгатай оролцож дэмжиж ажиллах.

2.3.2.4. Аливаа нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэхдээ архигүй тэмдэглэж байх хөдөлгөөн өрнүүлж, өсвөр үе залуучуудын чөлөөт цагийг зүй зохистой өнгөрүүлэх тааламжтай орчинг бүрдүүлж ажиллах.

2.3.2.5. Архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршиг, хэрэглээний талаар нийт хүн амын мэдлэгийг дээшлүүлэх талаар сургалт зохион байгуулах.

2.3.2.6. Иргэдийн хандлагыг өөрчлөх, архины хамааралтай иргэдэд чиглэсэн эрүүл зөв амьдрах чиглэлээр лекц сургалт, уулзалт ярилцлага зохион байгуулах.

2.3.2.7. Орон нутгийн телевизээр архи согтууруулах ундааны зүйлийн талаар зар сурталчилгаа явуулахгүй байх, архи эрүүл мэндэд хэрхэн хор, хохирол учруулдаг талаар 7 хоногт 2-3 удаа эрүүл мэндийн байгууллагаас мэдээ мэдээлэл нэвтрүүлэг явуулдаг байх.

2.3.3. Гуравдугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

2.3.3.1. Архинд донтох өвчин эмгэгийг эрүүл мэндийн суурь тусламжийн хүрээнд эрт илрүүлэх, эмчлэгдсэн хүнийг хяналтад авах арга хэмжээг зохион байгуулах

2.3.3.2. Аймгийн нэгдсэн эмнэлгийн Наркологийн тасгийг бэхжүүлэх, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2.3.3.3. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хамтарсан багийн чадавхыг дэмжиж, тохиолдол бүр дээр холбогдох этгээдийг эрүүлжүүлэх, эмчлэх соён гэгээрүүлэх арга хэмжээнд татан оролцуулах.

2.3.3.4. Архины хамаарлаас татгалзах хүсэлтээ гаргасан, гэрээ байгуулсан иргэдийн зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтад хамруулах.

2.3.4. Дөрөвдүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

2.3.4.1. Сургалт, эмчилгээнд хамрагдаж, архины асуудлаа шийдвэрлэсэн иргэдийг аймгийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар, Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн материаллаг баазад түшиглэн мэргэжил олгох сургалтад хамруулах.

2.3.4.2. Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт ажил олгогчоос ирүүлсэн ажлын байрны захиалгын дагуу архины асуудлаа шийдвэрлэсэн иргэдийг ажилд зуучлах, хөнгөлөлттэй зээл тусламж төсөл, хөтөлбөрт хамруулах замаар нийгэмшүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

2.3.4.3. Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн ажлын байрны судалгааг жил бүр нэгтгэн гаргах.

2.3.4.4. Эмчилгээ сургалтад хамрагдан архины асуудлаа шийдвэрлэсэн иргэдэд зориулан “Талархлын баяр” нэртэй арга хэмжээг зохион байгуулж, орон нутгийн телевизээр сурталчлах.

2.2.5. Тавдугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

2.2.5.1. Архидан согтуурсан иргэн, архи хэрэглэх нөхцөл бололцоог зохион байгуулалттай бүрдүүлсэн байгууллагын удирдлагад арга хэмжээ авч, зөрчил дутагдал, нөхцөл байдлыг арилгах албан мэдэгдэл, шаардлага хүргүүлж хэрэгжилтийг тооцох.

2.2.5.2. Архи согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдан борлуулах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, зөрчил бүрд хариуцлага тооцож ажиллах.

2.2.5.3. Согтууруулах ундааны хууль бус худалдаа үйлчилгээ, хэрэглээний хязгаарлалтад тавигдсан хяналтыг сайжруулж, таслан зогсоох арга хэмжээ авах.

2.2.5.4. Архины хууль бус зар сурталчилгаанд тавих хяналтыг сайжруулж хууль тогтоомж, стандарт зөрчиж худалдаа үйлчилгээ явуулсан, сурталчилгаа хийсэн иргэн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага тооцох.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа,

3.1. Хөтөлбөрийг 2018-2020 онд хэрэгжүүлнэ.

Дөрөв.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт,

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан зөвлөл эрхэлнэ.

4.2. Зөвлөл нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавих бөгөөд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажлыг жил бүр нэгтгэн дүгнэж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулан мэдээлж байна.

4.3. Сум орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар ахлуулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл гүйцэтгэнэ.

4.4. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагад хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүргийг тэдгээрийн удирдлагын шийдвэрээр томилогдсон салбар зөвлөл хариуцна.

4.5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, гэр бүл, хамт олон дараахь үүрэг хүлээнэ:

4.5. 1. Аймаг, сум, багийн ИТХ, Засаг дарга

4.5.1.1. “Архигүй–Алтайчууд” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг жил бүр аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж дүгнэлт өгөх.

4.5.1.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагааны санхүүжилтийг орон нутгийн төсөвт тусган батлуулах.

4.5.1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулж ажлын мэдээлэл танилцуулгыг хагас, бүтэн жилээр аймаг, сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, үнэлгээ дүгнэлт өгч ажиллах.

4.5.1.4. Согтууруулах ундаа худалддаг /үйлчилдэг/ цэгийн тоог цөөрүүлэх, эрүүл мэнд, хүүхэд, залуучууд, боловсролын байгууллагын орчинд согтууруулах ундааг худалдахгүй /үйлчлэхгүй/ байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах;

4.5.1.5. Согтууруулах ундаа худалддаггүй, үйлчилдэггүй, хэрэглэдэггүй сар, өдөр, цагтай болох шийдвэр гарган хэрэгжилтийг хянах, үр дүнг тооцох;

4.5.1.6. Архи хэрэглэх уламжлалт ёс заншлыг хэвшүүлэх, аливаа баяр ёслол, тэмдэглэлт үйл явдлыг архигүй тэмдэглэх талаар нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд тодорхой зорилт тавьж хэрэгжүүлэх;

4.5.1.7. Архийг байнга хэтрүүлэн хэрэглэдэг, согтуугаар хэрэг зөрчилд ордог болон архинд донтох өвчтэй хүмүүсийн судалгааг гарган мэргэжлийн байгууллагатай хамтран тусгай хөтөлбөрөөр урьдчилан сэргийлэх, эмчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах, энэ чиглэлээр мэргэжлийн байгууллага, мэргэжилтэнд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

4.5.1.8. Архинд донтох өвчтэй хүнийг сайн дураар нь хаяггүй эмчилгээнд хамруулах, зайлшгүй шаардлагатай тохиолдолд албадан эмчлэх ажлыг зохион байгуулах, архинаас гарах эмчилгээ хийлгэсэн хүмүүсийн ахуй амьдралд туслах, ажлын байраар хангах арга хэмжээ авч байх;

4.5.1.9. Архидан согтуурахаас сэргийлэх талаар тодорхой ажил зохион үр дүнд хүрсэн байгууллага, хамт олонд дэмжлэг үзүүлэх, тэдний үйл ажиллагааг сурталчлах, урамшуулах;

4.5.1.10. Байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дүгнэхдээ архидан согтуурахаас сэргийлэх талаар хийсэн ажил, түүний үр дүнг нэг үзүүлэлт болгон сайн ажилласан байгууллага, хамт олныг дэмжин урамшуулж байх;

4.5.1.11. Ажлын цагаар, ажлын байран дээр болон албан үүргээ гүйцэтгэж байгаа үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн төрийн албан хаагчдад хуулийн дагуу хариуцлага тооцож, үр дүнг иргэд олон нийтэд мэдээлэх.

4.5.2. Боловсрол соёл урлагийн газар:

4.5.2.1. Багш, эцэг, эхчүүдэд хүүхэд, өсвөр үеийнхэнд зөв үлгэр дууриалал үзүүлэх, хүүхдийн нас, сэтгэл зүй, бие бялдрын онцлог, харилцааны соёлын талаар сургалт явуулж гэр бүл, сургуулийг хүчирхийллээс ангид байлгах талаар олон талт ажил зохион байгуулах;

4.5.2.2. Бүх шатны боловсролын байгууллагын хичээлийн болон дотуур байрны гадаад, дотоод орчныг архигүй орчин байлгах, сургууль төгсөлтийн болон хонхны баяр, багш нарын өдөрлөг, сургуулийн ой зэрэг тэмдэглэлт үйл явдлыг согтууруулах ундаагүй тэмдэглэж занших;

4.5.2.3. Сургуулийн насны хүүхдийг сургуульд бүрэн хамруулах, сургууль завсардахаас сэргийлэх, завсардсан хүүхдийг сургалтад хамруулах, хичээлийн чөлөөт цагаар хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл зан үйл төлөвшүүлэхэд үр нөлөө үзүүлэхүйц биеийн тамир, спорт, соёл, урлагийн төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах, нөхцөл боломжоор хангах, эдгээр арга хэмжээнд хамрагдах хүүхдийн тоог өргөжүүлэх;

4.5.2.4. Оюутан, сурагчдын дунд архидан согтуурахын хор уршиг, түүнээс сэргийлэх, ардын уламжлалт ёс заншлын талаар хичээлээс гадуур цуврал хичээл, уулзалт ярилцлага, бага хурал, мэтгэлцээн, үзэсгэлэн, ханын сонин, зураг, зохион бичлэгийн уралдаан зохион байгуулах, сургуулийн дотоод, гадаад орчинд архины эсрэг сурталчилгааны самбар, санамж, зурагт хуудас байрлуулах зэргээр хүмүүжлийн ажлыг тогтмолжуулах;

4.5.2.5. Өсвөр үе, хүүхэд залуучуудын хичээлээс гадуурх секц, дугуйланг олноор хичээлүүлж, хорт зуршилгүй эрүүл орчин бий болгох.

4.5.3. Эрүүл мэндийн газар:

4.5.3.1. Архинд донтох өвчнийг эрүүл мэндийн суурь тусламжийн хүрээнд эрт илрүүлэх, эмчлэгдсэн хүнийг хяналтанд авах арга хэмжээг зохион байгуулах;

4.5.3.2. Согтууруулах ундааны хор нөлөө, архинд донтох өвчний талаар хүүхэд, залуучууд, нийт хүн амын дунд явуулах эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, энэ чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран арга зүйн зөвлөгөө өгч ажиллах;

4.5.3.3. Архинд донтох өвчний үед үзүүлж буй эмчилгээний үр дүнг судлах;

4.5.3.4. Аймгийн нэгдсэн эмнэлгийн Наркологийн тасгийг бэхжүүлэх, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

4.5.4. Цагдаагийн газар:

4.5.4.1. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон этгээдийг эрт илрүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч, гудамж талбай, олон нийтийн үйлчилгээний газарт хийх хяналт шалгалт, эргүүлийг тогтмолжуулах;

4.5.4.2. Хууль бусаар болон стандартын бус архи худалдсан, үйлчилсэн, насанд хүрээгүй хүнийг уруу татан архи уулгасан этгээдийг илрүүлэн тухай бүр арга хэмжээ авч байх;

4.5.4.3. Архидан согтуурсан гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг арилгуулах албан мэдэгдэл, шаардлага хүргүүлж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллах.

4.5.4.4. Архи согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэйгээр худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийх.

4.5.4.5. Архидан согтуурсны улмаас байнга эрх зүйн зөрчил гаргагчдын судалгааг гаргаж гэр бүл, хамт олонтой нь хамтран ажиллах;

4.5.4.6. Архидан согтуурсны улмаас удаа дараа хэв журам зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн, тээврийн хэрэгсэл жолоодсон этгээдийг тухай бүр сэтгэц-наркологиин эмчийн үзлэг, шинжилгээнд оруулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.

4.5.5. Хөдөлмөр халамж үйлчилгээний газар:

4.5.5.1. Архины асуудлаа шийдсэн, эмчлэгдэж эрүүлжигдсэн иргэдийг мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамруулах;

4.5.5.2. Архины асуудалтай хүмүүсийг байнгын болон түр ажлын байраар хангах, ажлын байранд зуучлах, хөдөлмөр зохицуулалт хийх, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах, нийтийг хамарсан ажилд оролцуулах;

4.5.5.3. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх бололцоог өргөтгөх, олон улсын төсөл хөтөлбөрт хамруулахад дэмжих.

4.5.6. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар;

4.5.6.1. Архи согтууруулах ундаанаас хамааралтай эцэг, эх асран хамгаалагчдын талаарх судалгааг цагдаагийн газартай хамтран гаргаж, тусгай хөтөлбөр, удирдамжийн дагуу сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах;

4.5.6.1. Архинаас үүдэлтэй эсрдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлийн гишүүдэд сэтгэл зүйн цочрол, хямрал, гэмтлээ даван туулахад туслах, сэтгэл зүйн зөвлөгөө заслын үйлчилгээ үзүүлж шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллага, мэргэжилтэнтэй холбон зуучлах.

4.5.7.Төрийн байгууллага, төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллага, аж ахуйн нэгж:

4.5.7.1. Байгууллага бүр архигүй орчин бүрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, бүх нийтийг уриалах, манлайлан оролцох;

4.5.7.2. Архидан согтуурахаас сэргийлэх, зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар ажиллагчдын мэдлэг, хандлагыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт,

сурталчилгаа зохиох, энэ талаар амжилт олж байгаа нэгж, ажилтанг дэмжих, сурталчлах, тодорхой урамшуулал бий болгох;

4.5.7.3. Архидан согтуурахад нөлөөлөх орчин нөхцөл, сөрөг хүчин зүйлийг арилгаж, байгууллага, хамт олны дотор эерэг уур амьсгал, сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх талаар төлөвлөн ажиллах;

4.5.7.4. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрэм, хөдөлмөрийн гэрээнд ажлын цагаар, ажлын байранд, албан үүргээ гүйцэтгэж байгаа үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой тусган хувь хүний үүрэг хариуцлага сахилга батыг өндөржүүлэх;

4.5.7.5. Ажиллагчдынхаа зан үйлийг судлан хамт олны чөлөөт цагийг зүй зохистой өнгөрүүлэх талаар тодорхой төлөвлөгөөтэй ажиллаж биеийн тамир, спортын уралдаан тэмцээн, урлаг соёлын арга хэмжээ зохион байгуулж байх;

4.5.7.6. Архийг байнга хэтрүүлэн хэрэглэдэг, согтуугаар хэрэг, зөрчилд холбогддог болон архинд донтох өвчтэй албан хаагчдын судалгааг гарган мэргэжлийн байгууллагатай хамтран тусгай хөтөлбөрөөр эмчилгээ, нөхөн сэргээх арга хэмжээнд хамруулах;

4.5.7.7. Архины хамаарлын улмаас эмчилгээ хийлгэсэн хүнийг ажлаа үргэлжлүүлэн хийх, хөдөлмөрийн чадварт нь тохирох ажилд авч ажиллуулах;

4.5.7.8. Архины асуудалтай хүн, түүний гэр бүлд дэмжлэг үзүүлэх, хууль эрх зүй, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах, энэ чиглэлээр бусад байгууллагатай хамтран ажиллах;

4.5.7.9. Аж ахуйн нэгж, байгууллагууд нийгмийн хариуцлагаа нэмэгдүүлж, архидан согтуурахын эсрэг сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах;

4.5.7.10. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэхдээ согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, бүх нийтийн хөдөлгөөн уриалгад нэгдэх.

4.5.8. Иргэн, гэр бүл, олон нийт

4.5.8.1. Иргэн бүр архины хор уршгийн талаар зохих мэдлэгтэй болж үр хүүхэд, гэр бүлийнхэндээ тайлбарлан таниулах, хүүхэд, залуучуудыг багаас нь эрүүл амьдрах ухаанд сургах;

4.5.8.2. Архины асуудалтай хүн, түүний гэр бүлд мэргэжлийн байгууллага, хүмүүсээс хууль эрх зүй, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, олон нийтийн зүгээс энэ чиглэлээр туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

4.5.8.3. Насанд хүрэгчид, эцэг, эхчүүд согтууруулах ундааг зүй зохистой хэрэглэх уламжлалт зан үйлээ сэргээн хэвшүүлэх, хүүхэд, залуучуудад зөв үлгэр дууриалал үзүүлэх;

4.5.8.4. Холбогдох хууль тогтоомжийн биелэлт, хөтөлбөрийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавих.

Тав.Хөтөлбөрийн санхүүжилт:

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

5.1.1. Улсын болон орон нутгийн төсвийн дэмжлэг.

5.1.2. Олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөр.

5.1.3. Иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, түүнчлэн олон улсын болон гадаадын байгууллага, иргэд, харьяалалгүй хүнээс үзүүлсэн хандив, тусламжийн хөрөнгө.

Зургаа. Хөтөлбөрийн үр дүн:

6.1. Хүрэх үр дүн:

6.1.1. “Архигүй-Алтайчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна.

6.1.2. Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж болон өрх, гэр бүлд архигүй эрүүл орчин бүрдсэн байна.

6.1.3. Архинд донтох өвчин эмгэг буурч архины асуудлаа шийдвэрлэсэн иргэдийн тоо жил тутам өссөн байна.

6.1.4. Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн түвшин тодорхой хувиар өсч өрхийн орлого нэмэгдсэнээр ажилгүйдэл ядуурал буурсан байна.

6.1.5. Иргэд олон нийт архины хор хөнөөлийн талаарх мэдлэгтэй болж, эрүүл зөв амьдрах хандлага нэмэгдсэн байна.

6.1.6. Архины хэрэглээнээс үүдэн гарах гэмт хэрэг, хүн амын өвчлөл, нас баралт, хүчирхийлэл, осол гэмтлийн тоо, үзүүлэлт буурна.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлт дүгнэлт өгөх, хөтөлбөрийг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх асуудлаар санал боловсруулах ажлыг хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөл холбогдох байгууллагуудтай хамтран гүйцэтгэнэ;

5.2. Орон нутагт хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хариуцан гүйцэтгэнэ.

5.2. Үр дүнг үнэлэх үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн		
		2018 он	2019 он	2020 он
“Архигүй –Алтайчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч, Архидалттай тэмцэх урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх.				
1	Эрүүл аюулгүй орчин бүрдүүлсэн төсөвт болон аж ахуйн нэгж байгууллагын эзлэх хувь	30 %	75 %	100 %

2.2.2. Архидан согтуурснаас эрүүл мэнд, гэр бүл, хамт олон нийгмийн амьдралд учрах хор уршгийн талаарх хүн амын мэдлэг, хандлагыг дээшлүүлэн эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх					
2	Архидан согтуурахтай тэмцэх сэргийлэх мэдээлэл сурталчилгааны тоо	урьдчилан чиглэлээр сургалт	25 %	50 %	60 %
2.2.3. Архинд донтох өвчин эмгэгийг эрт илрүүлэх, эмчлэн эдгэрүүлэх үйлчилгээг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотой зохион байгуулж үр дүнг тооцох.					
3	Архинд донтох болон архины хамааралтай хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн өсөлт		5 %	10 %	15 %
	Архины асуудалтай иргэдэд үзүүлсэн нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийн өсөлт		5 %	10 %	15 %
2.2.4. Архинаас татгалзсан, эмчлэгдэж эрүүлжсэн хүнийг нийгэмшүүлэх, дэмжих үйлчилгээг хөгжүүлэх:					
4	Архины хамаарлаас гарсан эмчлэгдсэн иргэдийг мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамруулах.		3 %	5 %	10 %
5	Ажлын байраар хангах, байнгын болон түр ажлын байранд зуучлах, нийтийг хамарсан ажилд оролцуулах		3 %	5 %	10 %
2.2.5. Архидан согтуурснаас нийгэмд учрах гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах, архи согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид тавих хяналт, нийгмийн хариуцлагыг сайжруулах.					
6	Эрүүлжүүлэгдсэн хүний тоо бууралт хувиар /өмнөх оны мөн үетэй харьцуулсан бууралтын хувь /		5 %	5 %	5 %
7	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн бууралт		3 %	3 %	3 %
8	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийн бууралт		5 %	5 %	5 %
9	Тусгай зөвшөөрөлтэй цэгийн тооны бууралт		2 %	3 %	5 %

---oOo---